



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 5/36.

Ховд

Т.Лхагвасүрэнг томилох тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар “Улс төрийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэх тогтоох тухай” тогтоолын 1 дэх заалтууд, Манхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 05/12935 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Түмэндэмбэрэлийн Лхагвасүрэнг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн Манхан сумын Засаг даргаар томилсугай.

2. Т.Лхагвасүрэнд Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын “Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох” 11 дүгээр хавсралтын дагуу 1052207 төгрөг /Нэг сая тавин хоёр мянга хоёр зуун долоон/-өөр цалинжуулж, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 30 хувиар тооцон сар бүр бодож олгохыг Манхан сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Б.Гансүх/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Т.Лхагвасүрэнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zan-5/36-Bo